

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН  
ТУШААЛ**

2023 оны ...дүгээр  
сарын ....-ны өдөр

Дугаар А/...

Улаанбаатар  
хот

**Журам шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Донорын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Амьд донор болон цусны хүндэт донорыг сувилуулах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Ундрал/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Учрал /-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны “Журам батлах тухай” А/43 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй

ГАРЫН ҮСЭГ

## **АМЬД ДОНОР БОЛОН ЦУСНЫ ХҮНДЭТ ДОНОРЫГ СУВИЛУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Донорын тухай хуулийн 22.1-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор дотоодын магадлан итгэмжлэгдсэн рашаан сувилалд донор иргэнийг үнэ төлбөргүй сувилуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журамд холбогдох шалгуур, нөхцөлийг хангасан Донорын тухай хуулийн 3.1.2-т заасан “амьд донор” иргэн донор болсноос хойш 5 жил дараалан жилд 1 удаа, 35-аас дээш удаа цусаа өгч Монголын улаан загалмайн нийгэмлэгийн “Цусны хүндэт донор”-ын болзол хангасан иргэн жилд 1 удаа хамрагдах эрхтэй.

### **Хоёр. Рашаан, сувиллын хөнгөлөлт олгох**

2.1.Цус сэлбэлт судлалын үндэсний төв 35-аас дээш удаа цусаа өгсөн цусны хүндэт донорын дэлгэрэнгүй мэдээлэл /овог, нэр, регистрийн дугаар, оршин суух харьяалал/-ийг жил бүрийн 02 дугаар сар, 07 дугаар сарын 01-ний дотор албан бичгээр болон цахим хэлбэрээр нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.2.Эрүүл мэндийн хөгжлийн төв амьд донор болсон иргэдийн дэлгэрэнгүй мэдээлэл /овог, нэр, регистрийн дугаар, оршин суух харьяалал/-ийг жил бүрийн 02 дугаар сар, 07 дугаар сарын 01-ний дотор албан бичгээр болон цахим хэлбэрээр нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.3.Энэхүү журмын 2.1, 2.2-т заасан байгууллагууд амьд донор, цусны хүндэт донорын мэдээллийн үнэн бодит, бүрэн байдал, нууцлалыг хариуцаж хамгаална.

2.4 Мэдээллийн үнэн зөв эсэхэд донорын эрх ашгийг хамгаалах иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж болно.

2.5.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 2.1, 2.2-т заасан мэдээллийг халамжийн нэгдсэн систем “ehalamj”-д оруулна.

2.4.Амьд донор, цусны хүндэт донор нь рашаан сувиллын хөнгөлөлт авах хүсэлтээ халамжийн нэгдсэн систем “ehalamj”-д дамжуулан цахимаар эсхүл сум, хорооны нийгмийн ажилтанд хандан цаасан хэлбэрээр дараах баримт бичгийг бүрдүүлэн гаргана:

- 2.4.1. өргөдөл;
- 2.4.2. иргэний үнэмлэх;
- 2.4.3. рашаан сувиллын эрхийн бичгийн хуулбар;
- 2.4.4. рашаан сувиллын үнэ төлсөн баримт;
- 2.4.5. замын зардал төлсөн баримт;

2.4.6. энэхүү журмын 2.4.1-2.4.5-д заасан баримт бичгээс гадна цусны хүндэт донорын хувьд Цус сэлбэлт судлалын үндэсний төв, түүний харьяа орон нутгийн салбар төвийн тодорхойлолт, амьд донорын хувьд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн амьд донор болох тухай тодорхойлолт.

2.5. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь халамжийн нэгдсэн систем “ehalamj” дахь амьд донор, цусны хүндэт донорын мэдээлэл болон энэхүү журмын 2.4-т заасан баримт бичгийг үндэслэн рашаан сувиллын эрхийн бичгийн үнэ, замын зардлын үнийг нийгмийн халамжийн сангаас олгоно.

2.6. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь амьд донор, цусны хүндэт донор нь эрүүл мэндийн даатгалтай бол рашаан сувиллын үнийг эрүүл мэндийн даатгалтай иргэний энгийн өрөөний тарифаар, эрүүл мэндийн даатгалгүй бол даатгалгүй иргэний төлөх тарифаар, хугацааг 7 хүртэлх хоногоор тооцон олгоно.

2.7. Рашаан сувилалд ирж, очих замын зардлыг автотээврийн болон агаарын тээврийн тарифт үнээр тооцон олгоно.

2.8. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь амьд донор, цусны хүндэт донорын рашаан сувиллын хөнгөлөлтийн мөнгийг тухайн иргэний халамжийн нэгдсэн систем “ehalamj”-д бүртгэлтэй арилжааны банкны дансанд шилжүүлнэ.

2.9. Төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан авах боломжтой мэдээллийг иргэнээс давхардуулан шаардахгүй.

## **Гурав. Бусад**

3.1. Энэхүү журмын хэрэгжилтэд нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага тус тусын хяналт тавина.

3.2. Энэхүү журамд заасан баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, худал мэдээлсэн, буруу тогтоосон байгууллага, албан тушаалтан, иргэнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэж, илүү олгогдсон төлбөрийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

3.3. Амьд донор, цусны хүндэт донорын талаарх мэдээллийг хууль бусаар ашигласан бусдад дамжуулсан тохиолдолд мэдээллийн нууцыг алдсан, түгээсэн

байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

----oOo----

ТӨСӨЛ